

## **6. "УЛААНБААТАР ХОТЫН ДААТГАЛ" ХХК**

1. Даатгалын зүйлийг согтуугаар жолоодох болон гэмт хэргийн зорилгоор ашиглаж явах үед учирсан хохирол;
2. Бусдын автотээврийн хэрэгсэлд учруулсан хохирол;
3. Даатгалын баталгаа буюу гэрээнд нэр нь ороогүй жолооч жолоодож явсан үед учирсан аливаа хохирол;
4. Дугуй болон дугуйнаас үүдэн учирсан хохирол;
5. Нэмэлт тоноглолд учирсан хохирол;
6. Даатгалтай автотээврийн хэрэгсэл дотор байсан эд зүйлс болон тээвэрлэж явсан ачаанд учирсан хохирол;
7. Ан ав хөөх болон уралдааны зориулалтаар ашиглаж явсанаас үүдсэн хохирол;
8. Механик эвдрэл болон мотор цохисон нөхцөлд;
9. Жолоодох эрхийн үнэмлэхгүй, жолоодох эрх нь хасагдан хүн жолоодсоноос үүдсэн хохирол;
10. Хүн тээвэрлэх зориулалтын бус автотээврийн хэрэгслээр хүн тээвэрлэсний улмаас үүссэн хохирол;
11. Автотээврийн хэрэгсэлийн эд ангийн зориулалт, ашиглалтын горимыг өөрчилснөөс үүдэн гарсан хохирол;
12. Техникийн бүрэн байдлыг хангаж яваагүйн улмаас үүдэн гарсан хохирол (МУ-ын замын хөдөлгөөнийн дүрмийн 2.3а-г зөрчсөн бол);
  - 12.1 Хөдөлгөөнд оролцохын өмнө буюу замд явахдаа энэ дүрмийн 2 дугаар хавсралтад заасан зөрчилгүй байхаар тээврийн хэрэгслийнхээ бүрэн бүтэн байдлыг хангах; Тээврийн хэрэгслийн ажлын тоормосны систем, жолооны механизм ажиллахгүй болсон, чиргүүлийн холбоос эвдэрсэн, харанхуй буюу үзэгдэлт хангалтгүй үед зөв талын хол, ойрын болон ар талын оврын гэрлүүд асахгүйболсон, цас, бороо орж байгаа үед жолоочийн талын шил арчуур ажиллахгүй бол хөдөлгөөнөө үргэлжлүүлэхийг хориглоно;
  - 12.2 Хөдөлгөөнд оролцож явах үед тээврийн хэрэгсэлд дээр дурдсанаас бусад гэмтэл (энэ дүрмийн 2 дугаар хавсралтад заасан) тохиолдвол түүнийг засах, хэрэв бололцоогүй бол аюулгүй байдлыг хангаж аль ойр байгаа зогсоол (гарааш) буюу засварын газарт очно;
  - 12.3 Хамгаалах бүсээр тоноглогдсон автомашин жолоодохдоо хамгаалах бүс хэрэглэх, хамгаалах бүс хэрэглээгүй зорчигч тээвэрлэхгүй байх; Тайлбар: Энэ заалт нь жолоодлогын дадлага хийлгэж яваа багш, үүргээ гүйцэтгэж яваа шуурхай албаны автомашины жолооч, зорчигчид хамаарахгүй;
  - 12.4 Мотоцикль жолоодохдоо хамгаалах малгай өмсөх, хамгаалах малгай өмсөөгүй зорчигч тээвэрлэхгүй байх;
  - 12.5 Согтууруулах ундаа, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл хэрэглэсэн эсэхийг цагдаагийн ажилтны шаардлагаар зохих журмын дагуу шалгуулах;
  - 12.6 Зам тээврийн осолд нэрвэгдсэн хүнд эмнэлгийн анхны тусламж үзүүлэх, түүнийг эмнэлэгт яаралтай хүргэх;
  - 12.7 Зам тээврийн осол буюу техникийн саатлаар замд зогссон жолоочийн дохиог оорзогсож, бололцоотой тусламж үзүүлэх;
  - 12.8 Замын хөдөлгөөнд аюул учруулж болзошгүй элдэв саад гарсан тохиолдолд түүнийг арилгах, хэрэв бололцоогүй буюу зам тээврийн осол гарсан бол энэ тухай хөдөлгөөнд оролцогчдод урьдчилан анхааруулж аль ойр байгаа цагдаагийн байгууллагад яаралтай мэдэгдэх;
  - 12.9 Гэмт хэрэг, үйлдвэрлэлийн осол, гал түймэр гарсан, байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул тохиолдсон, нийтийн эмх замбараагүй байдал үүссэн газарт хүрэлцэн очих, гэмт этгээдийг мөрдөн хөөх, амь нас, эрүүл мэндэд нь ноцтой хохирол учирч болох гэмтэлтэй хүмүүсийг эмнэлэгт, гэмт этгээдийг цагдаагийн байгууллагад хүргэхэд тээврийн хэрэгслээрээ үйлчлэх.
13. Даатгагч болон ЗЦГ-т ослын талаар мэдэгдэлгүйгээр, тэдний зөвшөөрөлгүйгээр ослын газраас хөдөлсөн бол (МУ-ын замын хөдөлгөөнийн дүрмийн 2.5а, г-г зөрчсөн бол);

13.1 Тээврийн хэрэгслээ нэн даруй зогсоож, ослын дохионы гэрлээ асаах ба ослын зогсолтын тэмдгийг замын хөдөлгөөний дүрмийн 6.3-т заасан шаардлагын дагуу тавьж, тээврийн хэрэгсэл болон осолд холбогдол бүхий эд юмсыг байрнаас нь хөдөлгөхгүй байх;

14. Даатгалын зүйлийн ердийн элэгдэл, бараа материалын хэвийн хорогдол, ууршилт зэрэг тухайн эд хөрөнгө бараа материалын шинж чанараас шалтгаалан гарсан хохирол;

15. Тээвэрлэлтийнүедгарсанхохирол;

16. Ачааллыгхэтрүүлэхболонхэвийнбусбайдлыгбуйболгосоналиваатохиолдлоосүүссэнхохирол;

17. Ашиглалтынхугацаазаасанэдангиудболонтуслах, дагалдахматериалуудынхохирол;

18. Үйлдвэрлэлийнболонбуруусууриллуулсан,угсарсан,задалсанаасүүдэнгарсанболонтэдгээрийгзасварл асаналиваазардал;

19. Даатгалын зүйлийг бусдын барьцаанд тавих, бусдад түрээслэх, зээлдүүлэхдээсээ өмнө даатгагчид мэдэгдээгүй үед гарсан хохирол;

20. Зорчигчийн хамгаалалтын бүс хэрэглээгүйн улмаас автотээврийн хэрэгсэлд учруулсан хохирол;

21. Зориулалтынбусаргаармоторхалаахоролдлогохийсэнэсучирсанхохирол, түүнийүрдагавар;

22. Даатгалын тухай хуулийн 8.5 дээрх заалтууд

22.1 Даатгуулагч санаатайгаар хохирол учруулсан буюу даатгалын тохиолдол бий болох нөхцөл, орчныг бүрдүүлсэн;

22.2 Даатгуулагч даатгалын зүйлийн талаар даатгагчид худал мэдээлсэн, хуурамч бичиг баримт бүрдүүлсэн нь тогтоогдсон;

22.3 Даатгалын гэрээнд зааснаас бусад шалтгаанаар хохирол гарсан;

22.4 Гарсан хохирлыг даатгуулагч буруутай этгээдээр нөхөн төлүүлсэн;

22.5 Хууль тогтоомжид заасан бусад үндэслэл.